

Цахим хөгжил, инновац, харилцаа
холбооны сайдын 2026 оны 04 сарын 24
өдрийн 158 дугаар тушаалын хавсралт

“ЦАХИМ АЙМАГ - УХААЛАГ ХОТ” ЗӨВЛӨМЖ

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.4-т “Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд үзүүлэх төрийн үйлчилгээг тодорхойлж, шат дамжлагыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.”, 9.3.9-д “Хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг системийн дараагийн үе шатны технологийг хот байгуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.” 9.4.7-д “Мэдээллийг цахимжуулж, иргэдэд төрийн үйлчилгээг цогц байдлаар, цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ.” 9.4.16-д “Цахим засаглалын технологийг бүх түвшинд бүрэн хэрэгжүүлж, авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бодлогын 4.3 дахь хэсэгт “Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ.” мөн 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4.5-д “Хяналтын камер, урсгал мэдрэгч төхөөрөмжүүдийг иж бүрэн суурилуулан, хотын хөдөлгөөн, бохирдол, эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдлын мэдээллийг цаг алдалгүй авч шинжилгээ хийх, зохицуулах арга хэмжээ авах системийг нэвтрүүлж, хиймэл оюун ухаанд суурилсан гамшгийн эрсдэлийн удирдлага, менежментийг хөгжүүлнэ.”, 2.1.1.3-д “Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар Монгол Улсыг бүсүүдэд хувааж, төрөлжүүлэн хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэхийг тусгасан. Үүнд:

№	Бүс	Аймаг, хот	Төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэл
1.	Хангайн бүс	Архангай, Баянхонгор, Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс Өвөрхангай аймаг	бөгөөд хот байгуулалтын дэд бүс
2.	Баруун бүс	Баян-Өлгий, Говь-Эрчим хүчний төрөлжсөн бүс бөгөөд Алтай, Завхан, Увс, байгалийн аялал жуулчлалын дэд бүс Ховд аймаг	
3.	Хойд бүс	Булган, Орхон, Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн Хөвсгөл аймаг	бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс
4.	Говийн бүс	Говьсүмбэр, Аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бөгөөд Дорноговь, Дундговь, ногоон эрчим хүчний дэд бүс Өмнөговь аймаг	



5.	Төвийн бүс	Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг	Хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс
6.	Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг	Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс
7.	Улаанбаатарын бүсэд	Нийслэл Улаанбаатар хот ба түүний дагуул хотууд	Бүх чиглэлд

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолын 7 дугаарт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, аймгийн Засаг дарга нарт, мөн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 25 дугаар тэмдэглэлээр “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад даалгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Цахимаар нэн тэргүүнд” бодлогын зөвлөмж батлах тухай” 108 дугаар тогтоолын 2.1.7.1 дүгээрт “ухаалаг хот шийдлийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжид нэвтрүүлнэ.” гэж заасан.

Түүнчлэн төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээд цаасан хэлбэрээр, өөрийн биеэр очиж үйлчлүүлж байгаа процессыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын нийт хүчин төгөлдөр үйлчилж байгаа 430 гаруй хуулиас 109 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан 2023 онд Улсын Их Хурлаар батлуулсан. Мөн 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Хот, тосгоны хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглах”-ыг дэлгэрүүлэн тусгасан бөгөөд 14.3 дахь хэсэгт “Хот, тосгон нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан шаардлагыг хангасан мэдээллийн систем, түүний дэд бүтцийг ашиглана.” гэж заасан байна.

Хоёр. Өнөөгийн байдал

Манай улсын хувьд 1990-ээд оноос 2012 он хүртэл компьютер хангамж, интернэтийн сүлжээ, дэд бүтцийг шийдэх, Үндэсний дата төв байгуулах, бүртгэлийн нэгдсэн систем бий болгох зэрэг зорилтуудыг хэрэгжүүлж, 2012 оноос “Цахим засаг” (E-Government) үндэсний хөтөлбөр, төрийн мэдээлэл солилцооны “ХУР” болон танилт, нэвтрэлтийн “ДАН” системүүдийг бий болгож (2017, 2018), 2020 оноос төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-ийг хөгжүүлэн, 2021 онд мэдээллийн технологийн хөгжлийг дэмжих хуулиудыг баталж, 2022 онд “Цахим үндэстэн” баримтлах чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлж ирсэн.



Өнгөрсөн хугацаанд хийгдсэн цахим шилжилтийн үр дүнд Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2 жил тутамд гаргадаг “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ээр 2024 онд 46 дугаар байранд эрэмбэлэгдэж, өмнөх оноос 28 байр урагшилсан.

Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээг хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт нэвтрүүлэхэд чиглэсэн томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, нийт 59,030 км урт шилэн кабелийн сүлжээ байгуулж, бүх аймаг, сумын төв, томоохон суурин газруудад хөдөлгөөнт холбооны 3G, 4G/LTE сүлжээг нэвтрүүлсэн.

Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 2002 онд 235 мянга байсан бол 2025 оны хагас жилийн байдлаар 4 сая 961 мянгад хүрч, үүнээс 4G/LTE сүлжээний хэрэглэгчдийн тоо 4 сая 208 мянга болсон байна. Монголын Улсын хэмжээнд 1,650 баг байгаагаас 1,545 баг үүрэн холбооны сүлжээнд холбогдоод байна.

Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологийг (5G) нэвтрүүлэхэд баримтлах чиглэлийг 2020 онд баталж, 2021-2022 онд 5G технологийг нэвтрүүлэх техникийн туршилтыг амжилттай зохион байгуулсан. 2025 оны хагас жилийн байдлаар 2 сая хэрэглэгч 5G сүлжээнд холбогдсон.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад газрын дахин дамжуулах станцаар дамжуулан үндэсний олон нийтийн телевизийн 5 суваг, радиогийн 4 сувгаас гадна 134 телевиз, 64 радио үйл ажиллагаа явуулж байна.

Дэлхийн шуудан холбооноос жил бүр шинэчлэн гаргадаг Шуудангийн хөгжлийн индексээр (2IPD) Монгол Улс тогтвортой өсөлт үзүүлсээр байна. 2023 онд манай улс 46.7 оноотойгоор 6 дугаар түвшинд эрэмбэлэгдэж байсан бол 2025 онд 48.5 оноонд хүрч, хөгжлийн 7 дугаар түвшинд албан ёсоор дэвшлээ. Энэхүү амжилт нь 2022 онтой харьцуулахад нийт оноо 6-аар ахиж, хөгжлийн түвшний хувьд дахин нэг шатаар ахисан өндөр үзүүлэлт болж байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд цахим хөгжлийг дэмжих, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, саадгүй хүргэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар”-ыг Засгийн газрын 2022 оны 499 дүгээр тогтоолоор байгуулсан бөгөөд тус агентлаг нь төрийн цахим үйлчилгээний нэр төрөл, чанар, стандарт, хүртээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан төрийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах зорилгоор Улаанбаатар хотын хэмжээнд 143 цэгт, орон нутагт 420 цэгт, хилийн чанад дахь 31 улсын 47 цэгт буюу нийт 610 цэгт “ХУРДАН” цэгийг ажиллуулж байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2023 онд 21 аймгийн хэмжээнд 1,036 төрийн албан хаагч, 2,807 иргэдийг хамруулан судалгаа авч, аймгуудын цахим шилжилтийн бэлэн байдлын үнэлгээг удирдлага ба манлайлал, хандлага, ур чадвар, инновац гэсэн 5 үзүүлэлтээр үнэлсэн. Үүнд:



Эрэмбэ		0-25 оноо
1	Орхон	16.6
2	Хэнтий	16.2
3	Баянхонгор	16
4	Увс	15.7
5	Сүхбаатар	15.7
6	Говьсүмбэр	15.6
7	Говь-Алтай	15.2
8	Завхан	15.2
9	Архангай	15.1
10	Өвөрхангай	15.1
11	Ховд	14.9
12	Булган	14.8
13	Дархан-Уул	14.7
14	Дорнод	14.5
15	Дундговь	14.5
16	Баян-Өлгий	14.3
17	Төв	14.3
18	Өмнөговь	14.2
19	Сэлэнгэ	13.5
20	Хөвсгөл	13.5
21	Дорноговь	13.1

Монгол Улсын аймгуудын цахим шилжилтийн тайлан 2023

2023 оны байдлаар 21 аймгийн 11 нь "цахим", "дижитал", "ухаалаг" гэсэн зорилтот бодлого, хөтөлбөр, дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнээс гадна бүх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт цахимжилттай холбоотой зорилго, зорилт, үйл ажиллагаанууд туссан байна.

Аймгууд цахим шилжилтийн талаар олон талын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа боловч шинэ технологи дамжуулж нэвтрүүлэх хурд, шинэ хэрэглээ, зах зээл бий болгох боломж, орон нутгийн удирдлагын манлайлал, орон нутгийн мэдээлэл боловсруулж ашиглах чадвар, хүний нөөцийн байдал зэргээс шалтгаалж цахим шилжилтийн үйл явц аймаг, орон нутагт ялгаатай байна. Мөн ухаалаг, цахим аймаг, хотын талаарх ойлголт, мэдлэг зөрүүтэйгээс аймгуудын цахим бодлого ихэнх тохиолдолд цахим хуудас хөгжүүлэх, гудамж талбай камержуулах, компьютер сервер худалдаж авах, киоск машин байршуулах зэргээр үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байна.

2025 оны байдлаар нийт 330 сумын 328 нь шилэн кабельд холбогдсон бөгөөд сүлжээний нийт урт нь 60 мянга орчим км-т хүрсэн. 2026 онд Интернетийн гадаад урсгалын багтаамж 2021 онд 178,1 Гбит/сек байсан бол 2025 оны хагас жилийн байдлаар 218,7 Гбит/сек болж 22,8 хувь өссөн байгаа нь дотоодын хэрэглэгчдийн өндөр хурдны интернэт, видео стриминг, сошиал медиа хэрэглээний эрэлтийг хангах суурь болж байна. Энэхүү өсөлт нь цаашид 5G сүлжээг орон нутагт нэвтрүүлэхэд гол дэмжлэг болох болно. Улс хоорондын транзит урсгал 2021 онд 1,070 Гбит/сек байсан бол 2,300 Гбит/сек болж 2.1 дахин өссөн үзүүлэлттэй байна. Транзит урсгал



2 дахин нэмэгдсэн нь манай улс зөвхөн хэрэглэгч биш, бүс нутгийн мэдээлэл дамжуулах томоохон зангилаа (Hub) болсныг илтгэж байна.

“Жишиг цахим аймаг” төслийг 2024 оны 4 дүрээр сараас гэрээ байгуулан Өвөрхангай, Дархан-Уул аймагт хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2024 оны 10 дугаар сарын байдлаар Өвөрхангай аймагт шаардлагатай 9 систем, Дархан-Уул аймагт 10 системийг нэвтрүүлэн үйл ажиллагаандаа ашиглан иргэд аж, ахуй нэгжид Төрийн байгууллагуудын зохион байгуулалт сайжирч, үйл ажиллагааны зардал буурч, иргэн, аж ахуй нэгжид хүргэж буй үйлчилгээ ил тод, түргэн шуурхай болж байна.

Ийнхүү зарим нааштай үр дүн гарч байгаа хэдий ч, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд, сорилтууд байсаар байна. Үүнд өргөн уудам газар нутагт дэд бүтэц хүргэх буюу мэдээллийн сүлжээний хүртээмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт, бүх нийтийн цахим ур чадварын түвшин, мэдээллийн технологийн мэргэжлийн болон ур чадвартай хүний нөөцийн асуудал, төрийн байгууллагуудын процессын чирэгдэл, цахим шилжилтэд хойрго байдал зэрэг асуудлууд байсаар байна.

Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийн өнөөгийн байдал

Монгол Улсад 2018 онд Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны хүрээнд Мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах чадварыг үнэлэх зорилготой 9 асуулга бүхий судалгааг 15-49 насны эмэгтэй 10000, эрэгтэй 5000 нийт 15000 иргэнээс насанд хүрэгчид болон залуус гэсэн 2 ангиллаар авсан. Энэхүү судалгааны үр дүнгээр бүх нийтийн цахим ур чадварын үзүүлэлт эрэгтэйд 30%, эмэгтэйд 32%, дундаж үзүүлэлтээр 31% гэж тодорхойлогджээ.

Харин Үндэсний Статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 онд хамтран хэрэгжүүлсэн “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ” судалгаанд оролцогчдын 43.8% нь мэдээллийн ур чадвартай, 38.8% нь харилцаа холбооны ур чадвартай, 27% нь асуудал шийдвэрлэх ур чадвартай, 9.8% нь программ хангамжийн ур чадвартай, 6.4% нь аюулгүй байдлын ур чадвартай гэж үнэлэгдсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 42%-тай байна.

Хоёр. Тулгамдсан асуудал

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулан ажиллаж, 2024 оны 4 дүгээр сараас эхлэн "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн дагуу жишиг хэлбэрээр Дархан-Уул, Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн. Тус үйл ажиллагааны хүрээнд мэдээллийн системийн бүрдлийг төрийн мэдээлэл солилцооны ХУР систем, аж ахуйн нэгж байгууллагуудын системүүдтэй холболтыг хийж, аж ахуйн нэгж, иргэд төрийн байгууллага хоорондын уялдааг сайжруулж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хялбар авах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, шийдвэр гаргалтад цахим хэлбэрээр оролцох боломжийг бүрдүүлээд байна. Үүнтэй холбогдуулан 2024 оны 9 дүгээр сард Дархан-Уул аймагт, 10 дугаар сард Өвөрхангай аймагт тус тус очиж, хэрэгжилт, нэвтрүүлэлтийг газар дээр нь шалган, мэргэжил арга зүйн дэмжлэг



үзүүлэн ажилласан бөгөөд цаашид аймгийн хэмжээнд сургалт, нэвтрүүлэлтийг хийх замаар ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу хэрэгжих засаг захиргааны нэгжийн өөрчлөлт, хот суурин газруудын статусын өөрчлөлт, Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй холбогдуулан “Цахим аймаг” зөвлөмжийг аймаг болон улс, орон нутгийн зэрэглэл бүхий хотуудад хэрэгжүүлэхээр шинэчлэн өөрчлөх шаардлага урган гарч байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дугаар тогтоол болон “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан үйл ажиллагааны хөтөлбөрт бүсийг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлийг заасан бөгөөд түүнд тохирсон дэвшилтэт технологи, инновацын шийдлийг боловсруулах шаардлагатай байна.

Цаашид “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг шинэчилж, олон улсын чиг хандлага, стандарт, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хот тосгоны эрхзүйн байдлын өөрчлөлт, төлөвлөгдөн буй засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдуулж, “Ситиверси”, “Дижитал ихэр хот”, “Метаверси”, “AIoT” зэрэг технологийн шийдэл, шаардлагыг тодорхойлох шаардлагатай байна.

Гурав. Олон улсын чиг хандлага

Аж үйлдвэрийн IV хувьсгал буюу хиймэл оюун ухаан (AI), юмсын интернэт (IoT), их өгөгдөл (big data), блокчэйн, робот автоматжуулалт зэрэг технологийн үсрэнгүй хөгжил, физик болон дижитал, биотехнологи, геномикийн технологиудын нэгдлийн эрин зуунд дэлхийн улс орнууд ирээдүйн хөгжлийн чиг баримжаагаа тодорхойлон төлөвлөж, үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Мэдээллийн технологийн хөгжлөөр түүчээлж буй улс орнууд Засгийн газрын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээгээ 1990-2010 онд цахимжуулах (E-Government), 2010-2020 онд дижитал шилжилт хийж “Дижитал засаг” бүрдүүлэх (Digital Government) үе шатуудыг амжилттай хэрэгжүүлээд, эдүгээ “Бодьгалжсан засаг” (Personal Government) бий болгох үе шат руу шилжих зорилт тавин ажиллаж байна.

Мөн дэлхийн хотууд “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” (Digital city), “Ухаалаг хот” (Smart city) болох зорилтыг хэрэгжүүлж, сүүлийн үед “Ситиверси”, “Дижитал ихэр хот” зэрэг ирээдүйн дүр зураг, төсөөллүүдийг боловсруулан төлөвлөх болжээ. Дэлхий нийтээр засаг захиргааны нэгжид суурилсан ухаалаг хотын тогтвортой хөгжлийг чухалчилж байна. Жишээ нь Солонгос Улсын Сэжүн хот нь нотолгоонд-суурилсан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх замаар хотын нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх “Дижитал ихэр хот” технологийг хөгжүүлсэн бол өнөөдрийн байдлаар тус улсын Пусан хот нь “Дижитал ихэр хот” технологийг “Метаверси” технологитой хослуулсан “Ситиверси” хотын стандартчиллын чиг хандлагыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



Европын холбооны улс орнууд “Ситиверси” хотын стандартчиллын чиг хандлагыг “Дижитал европ” хөтөлбөрт тусгасан бөгөөд мэдээлэл харилцаа холбооны технологийн стандартчиллын Европын холбооны ажиглалтаар судлагдсан байна. Мөн Олон улсын стандартын байгууллагаас физик болон виртуал орчныг холбоход шаардагдах ISO/IEC 42010 буюу программ хангамж, систем, энтерпрайс архитектурын тодорхойлолт, ISO/IEC 30141 буюу IoT лавлагааны архитектурыг баталсан.

Дөрөв. Зорилго

Олон улсын чиг хандлага, стандарт, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хот, тосгоны эрхзүйн байдлын өөрчлөлт, төлөвлөгдөж буй засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдсан “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот”-ыг бий болгох


Тав. Хэрэгжүүлэх таатай орчин

“Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” болох таатай орчин гэдэгт эрхзүй, дүрэм журам, зохицуулалт, бодлогын хүрээ, улс төр, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс гээд бүхий л хүчин зүйлсийг хамруулж ойлгоно. Мөн байгууллага, хувь хүмүүс, хэрэгжүүлж буй аливаа хөтөлбөрийн үр өгөөжтэй, үр дүнтэй үйл ажиллагааг дэмжсэн хандлага, үйлдэл, журам, практикийг ч хамруулна.

Тухайн орон нутагт тохирсон шийдлийн зураглал гаргахдаа энэхүү баримт бичиг дахь бүх нөхцөл, шаардлагуудыг тусгах хэрэгтэй.

Хэрэгжүүлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд оролцогч талуудын хоорондын уялдаа холбоог нарийвчлан тооцоолж, зохицуулах шаардлагатай. Оролцогч талууд гэдэгт засгийн газар, бусад санхүүжүүлэгч, донор байгууллагууд, төрийн бус байгууллагууд, технологийн компаниуд, ханган нийлүүлэгч нар, технологийн дэд бүтэц болон төрийн үйлчилгээ үзүүлэгч талууд, эцсийн хэрэглэгчид ба дэмжигчид зэрэг багтана.

Хэрэгжүүлэх таатай орчинд дараах бүрдэл хэсгийг хамруулж ойлгоно. Үүнд:





Удирдлага, засаглалын бүрдэл нь бусад бүх талбарт нөлөөлнө. Үйлчилгээ, программ хангамж, стандартууд, хоорондын уялдаа холбоотой байдал, дэд бүтцийг нийлүүлэн нэг хэсэгт оруулж, технологитой холбогдох талбаруудыг багцалсан. Энэхүү хэрэгжүүлэх таатай орчны бүрдлийг бэхжүүлэх нь эргээд орон нутгийн ерөнхий тогтолцоог сайжруулахад тусална.

Хэрэгжүүлэлтийн таатай орчныг бүрдүүлэхэд зайлшгүй хийх шаардлагатай үйл ажиллагаа:

1. Удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх;
2. Бодлогын баримт бичиг боловсруулан хэрэгжүүлэх;
3. Шаардлагатай дүрэм, журмыг батлах;
4. Хэрэгжилтийг хангах бүтэц, зохион байгуулалтыг тодорхой болгох;
5. Санхүүжилтийг шийдвэрлэх (үүнд, зөвхөн анхны хөрөнгө оруулалтын зардал бус, цаашид гарах урсгал зардлыг тооцоолж, цогцоор нь шийдвэрлэх);
6. Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, бэлдэх;
7. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх;
8. Олон нийтэд сурталчлан таниулах, хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх.

5.1.Манлайлал, засаглал

“Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийг хэрэгжүүлэх тогтолцоог үүсгэх, хяналт тавих, уялдаа холбоог бий болгох, дүрэм журам тогтоох, архитектурт төлөвлөлт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд цахим шилжилтийн үйл ажиллагааг хариуцсан чиг үүрэг бүхий шийдвэр гаргах түвшний албан тушаалтныг томилж, үүрэгжүүлэх /Жишээ нь: Засаг даргын орлогч дарга байх нь зохимжтой./
2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх стратеги төлөвлөгөөтэй байх
3. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилго, зорилт нь цахим шилжилтэд чиглэсэн байх
4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан ерөнхий төлөвлөлтөд нийцүүлэн байгууллагын нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийг гаргасан байх
5. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн талаарх хууль тогтоомж, Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг харьяа байгууллагын хэмжээнд хангах үүрэг, хариуцлагын тогтолцоотой байх
6. “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийг хэрэгжүүлэх архитектур төлөвлөлттэй байх



5.2. Хөрөнгө оруулалт, санхүүжилт

1. “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийг хэрэгжүүлэх таатай орчин тус бүрд хөрөнгө оруулалт, зардлын тооцооллыг хийж, орон нутгийн төсөв, бусад төсөл хөтөлбөрийн санхүүжилттэй уялдуулан санхүүжүүлдэг байх
2. Хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн сум, дүүрэг, аймаг, нийслэлийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах замаар тухайн жилийн орон нутгийн төсөвт батлуулж, санхүүжүүлэх
3. “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлж, нэвтрүүлсэн үйл ажиллагааны цаашдын тогтвортой байдлыг хангах ашиглалт, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу холбогдох зардлыг шийдвэрлэх
4. “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийг хэрэгжүүлж, нэвтрүүлсний дараах хэмнэлт, үр ашиг, үр өгөөжийн тооцооллыг боловсруулах, тогтмол хугацаанд тайланг нэгтгэн дүгнэдэг байх

Сайн төлөвлөлт, зохицуулалттай цахим шилжилтийн үр дүнд хөрөнгө оруулалтын эрсдэлийг багасгадаг. Зургаар харуулбал:



5.3. Үйлчилгээ, программ хангамж

“Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн системүүд нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:





Төрийн мэдээллийн системд: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих систем, мэдээлэл хариуцагч байгууллагуудын систем, засгийн газрын захиалгаар бүтээсэн иргэд олон нийт, аж ахуйн нэгжүүдэд зориулсан системүүдийг хэлнэ. Үүнд:

- Үндсэн систем “ХУР”
- Дэмжих системүүд
 - танилт, нэвтрэлтийн систем;
 - нийтийн түлхүүрийн дэд бүтэц;
 - албан бичиг солилцооны дундын систем;
 - мэдээлэл солилцооны бүртгэлийн систем;
 - мэдэгдэл хүргэх систем;
 - төрийн үйлчилгээний нэгдсэн систем;
 - төлбөр тооцооны систем.
- Төрөөс иргэн, аж ахуйн нэгжид зориулсан нийтлэг системүүд
- Мэдээлэл хариуцагчийн системүүд: Яамд, агентлагууд, төрийн босоо удирдлагатай байгууллагуудын зүгээс үзүүлж буй үйлчилгээнүүдийг цахимжуулж, иргэн, аж ахуйн нэгжүүдэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тэгш хүргэх зорилготой бүтээгдсэн системүүдийг хэлнэ. (Төрийн болон мэдээлэл хариуцагчийн системүүдийг хавсралтаар оруулав.)

Нутгийн удирдлагын мэдээллийн системд: тухайн аймаг орон нутгийн удирдлагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, харьяа байгууллагуудын мэдээлэл солилцооны урсгалыг бий болгох, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналтын механизмыг бий болгох зорилгоор бүтээсэн системүүдийг хэлнэ.

- Нутгийн удирдлагын мэдээллийн системүүд;
- Иргэн, аж ахуйн нэгжид зориулсан системүүд;
- Орон нутгийн статистик мэдээлэл, удирдлагын хяналтын системүүд.

Жишээ нь “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн хүрээнд Дархан-Уул, Өвөрхангай аймагт нэвтрүүлсэн мэдээллийн системүүдийг дурдвал:

- 1 Өгөгдөл солилцооны үндсэн платформ;
- 2 Удирдлагын мониторинг дашбоард систем;
- 3 Иргэдэд зориулсан портал, аппликэйшн;
- 4 Байгууллагын удирдлагын систем;
- 5 Аж ахуйн нэгжийн систем;
- 6 Шуурхай удирдлага, хяналтын систем;
- 7 Орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх;
- 8 Төлбөр тооцооны систем;
- 9 Тээврийн хэрэгслийн нэвтрэлтийн систем;
- 10 Инженерингийн систем;
- 11 Хогийн машины хяналтын систем;
- 12 Салбарын шагналын бүртгэлийн систем;
- 13 Санхүүгийн программ.



Хувийн хэвшлийн мэдээллийн системд:

- Аж ахуйн нэгж байгууллага, компаниудын мэдээллийн системүүд.

Зөвлөмжийг хэрэгжүүлэхэд мэдээллийн системүүдэд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

1. Мэдээллийн эзнийг Монгол Улсын иргэний бүртгэлийн дугаараар таньж, тодорхойлдог байх (Гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол оршин суух үнэмлэхийн дугаарыг ашиглана.);
2. Мэдээлэл хариуцагч өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, давхардуулж үүсгэхгүй байхаар төлөвлөн хэрэгжүүлэх;
3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системд холбогдсон мэдээллийн системийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах;
4. Хариуцаж байгаа мэдээллийн системд хийгдсэн үйлдлийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;
5. Чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд үүссэн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах;
6. Мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр энэ хуулийн 27.8-д заасны дагуу бүртгүүлэх;
7. Мэдээллийн сангаас гарах тайлан, мэдээг системийн хэрэглэгч дурын маягтаар бэлтгэн гаргах, график дүрслэл бүхий (дашбоард) байдлаар харах, татаж авах боломжтой байх;
8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь заалтын дагуу нээлттэй өгөгдлийг мэдээллийн системд уншигдах хэлбэрээр байршуулах, хүн, хуулийн этгээд ашиглах боломжийг бүрдүүлж, "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем" (opendatagov.mn)-д холбох;
9. Хуулиар байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д холбох;
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд тохирсон байдал буюу Web Content Accessibility Guidelines (WCAG 2.2), User Agent Accessibility Guidelines (UAAG), Authoring Tool Accessibility Guidelines (ATAG) зэрэг веб контентын хүртээмжийн олон улсын стандартуудыг дагаж мөрдөх;
11. Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу цахим гарын үсэг, цахим тамгыг дэмждэг байх;
12. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтын дагуу танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-ийг дэмждэг байх;
13. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан мэдэгдэл хүргэх системтэй холбогдон ажилладаг байх;
14. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасны дагуу нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө дүгнэлт, зөвлөмж гаргуулсан байх;



15. Тухайн мэдээллийн системийг Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн “system.gov.mn” системд бүртгэсэн байх.

5.4. Стандарт, харилцан үйлчлэл

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэл хариуцагч хоорондоо болон мэдээлэл хариуцагчаас хүн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо үндсэн системийг ашиглах;
2. Үндсэн системтэй харилцан солилцох өгөгдөл, мэдээллийг тодорхойлсон байх /developer.xyp.gov.mn/;
3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар нийтийн мэдээллийн ангиллыг тодорхойлсон байх;
4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6, 27.7, 27.10 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж ажиллах;
5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх заалтын дагуу ашиглагдах нэгдсэн ангилал, код, тайлбарыг Цахим хөгжил харилцаа, инновац, холбооны яамтай хамтран баталж, хэрэглэх;
6. Үндсэн болон дэмжих системүүдийн техникийн нөхцөл, шаардлагад нийцүүлсэн байх;
7. Хариуцаж байгаа мэдээллийн санг хүн, хуулийн этгээдээс цахим хэлбэрээр ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
8. Өөрийн чиг үүрэгт хамаарах үйлчилгээг цахим хэлбэрээр болон нийтийн мэдээллийн дэд бүтэц ашиглан хүн, хуулийн этгээдэд үзүүлэх.

5.5. Дэд бүтэц, инновац

Мэдээллийн систем хөгжүүлэх суурь үндэс нь технологийн болоод харилцаа холбооны дэд бүтэц болно. Иймд харилцаа холбооны дэд бүтцийн бэлэн байдлыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Тухайн мэдээллийн системийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.11-д заасан нөхцөл, шаардлагыг хангаж нийтийн мэдээллийн дэд бүтцэд холбосон байх;
- Иргэдийн санал хүсэлт болон бусад нөхцөл байдалд үндэслэн одоо байгаа үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийн технологийг нэвтрүүлэн үйл ажиллагаа, үйлчилгээндээ инновацийн сайжруулалт хийдэг байх;
- Дэвшилтэд технологид зориулсан мэдээллийн технологийн нөөцийг тооцоолсон байх;
- Мэдээллийн технологийн техник хангамж, сүлжээ, түүний аюулгүй байдлын дэд бүтцийг бүрэн шийдвэрлэсэн байх.

5.6. Дүрэм журмын зохицуулалт, түүний хэрэгжүүлэлт

- “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийн үр дүнд хүрэхэд шаардлагатай төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх талаар



шаардлагатай судалгаа, дахин загварчлалын ажлыг хийх, асуудлыг тодорхойлох, сайжруулах зураглалыг гаргах;

- Шаардлагатай дүрэм, журмын шинэчлэлийг хийж, баталж, мөрдүүлэх;
- Тухайн байгууллага нь мэдээллийн систем ашиглах болон байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, аюулгүй байдлыг дотооддоо хангахтай холбогдсон журмыг баталсан байх.


5.7.Хүний нөөц

“Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн чиглэлээр дараах үйл ажиллагааг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хэмжээнд цахим шилжилтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан ёсны бүтэц, зохион байгуулалттай байх ба албан хаагч нарын ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд тусгаж, үнэлдэг байх;
- Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж, ажиллуулах (Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь хэсэг, УИХ-ын 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1.2 дугаар хэсэгт тус тус заасан);
- Иргэдийн цахим ур чадварын түвшнийг тогтоон, ур чадварыг дээшлүүлэх чиглэлд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлдог байх;
- Сум, аймаг, хот, орон нутгийн хэмжээнд хүний нөөцийн цахим ур чадварын сургалтыг тогтмол зохион байгуулах тогтолцоотой байх;
- Төрийн албан хаагчид иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүртээмжтэй төрийн үйлчилгээ үзүүлэхдээ цахим ашиглах хүсэл эрмэлзэлтэй ашиглаж хэвших.

Зургаа. “Цахим-Аймаг, Ухаалаг-хот” архитектурыг боловсруулах

“Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай архитектурыг сум, дүүрэг, аймаг, нийслэл, хот, бүс нутгийн онцлогт тохируулан, нийтийн мэдээллийн дэд бүтцэд уялдуулан боловсруулсан байна. Архитектурын шийдэл дараах дөрвөн давхаргаас бүрдэнэ. Үүнд



1. Ажлын үйл явцын давхарга:

Хүмүүсийн оролцдог үйл явцууд байх бөгөөд дүрэм журмын зохицуулалт, түүний хэрэгжүүлэлтийн хэсэгтэй шууд уялдаатай төлөвлөгдөнө.


2. Өгөгдлийн давхарга: Ажлын үйл явцын давхаргын хүрээнд ашиглаж, дамжуулж буй мэдээлэл өгөгдлийг хамарна.

3. Хэрэглээний программ хангамжийн давхарга: солилцож

буй мэдээлэл, өгөгдлийг хүлээн авч, хүргэж буй программ хангамжууд байна.

4. Технологи техник хангамжийн давхарга: дээрх давхаргуудыг дэмждэг техник хангамжийн иж бүрэн шийдэл байна.


Үүнээс хэрэглээний программ хангамжийн давхарга нь доорх зурагт үзүүлсэн үндсэн гурван бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:




1. Бүрэлдэхүүн хэсэг: Хуульд тусгайлан заасан улсын хэмжээнд нэгдсэн байдлаар ашиглаж буй программ хангамжууд болон тухайн аймаг, хот, орон нутгийн онцлогт тохирсон программ хангамжуудаас бүрдэнэ.
2. Уялдан ажиллах болон үйлчилгээний давхарга: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системийг хамруулна. Жишээ нь: төрийн мэдээлэл солилцооны систем “ХУР”, танилт нэвтрэлтийн “ДАН” зэрэг дундын системээс бүрдэнэ.
3. Үйлчилгээний цэгийн программ хангамжууд: Хүн, хуулийн этгээдэд буюу эцсийн хэрэглэгч нарт зориулагдсан программ хангамжийг хамруулна. Жишээ нь: төрийн үйлчилгээний нэгдсэн систем “e-mongolia.mn”, тухайн аймаг, хот, орон нутгийн иргэдийн хэрэглээний гар утасны аппликэйшн зэргээс бүрдэнэ.

Жишээ нь:

Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн жишиг архитектур



Дархан-Уул аймагт хэрэгжүүлсэн жишиг архитектур




“Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” архитектурыг өөрийн аймаг, хот, орон нутгийн онцлог тохируулан боловсруулж, хэрэгжүүлэх нь дараах үнэ цэнийг бий болгоно. Үүнд:

- Мэдээллийн систем болон технологийн салангид, үр өгөөжгүй байдал үүсэхээс сэргийлэх;
- Мэдээллийн системүүдийг төвлөрсөн байдлаар зохицуулах, үндэсний дэд бүтцэд уялдуулах;



- ## НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦ.



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу төрийн мэдээлэл солилцооны систем нь зөвхөн **суурь** болон **төрөлжсөн мэдээллийн сангийн** мэдээллийг төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд ашиглах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн систем байна. /Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.3, 18.9/

Үндсэн болон дэмжих системд холбогдсон суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийн үнэн зөвийг Дата төв болон И-Монгол академи хариуцахгүй. *Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам/*

Нийтийн мэдээллийн санг суурь мэдээллийн сан, төрөлжсөн мэдээллийн сан, байгууллагын мэдээллийн сан гэж ангилах бөгөөд суурь мэдээллийн санг хуулиар эрх



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

олгогдсон байгууллага хуульд заасны дагуу үүсгэн бүрдүүлэх бөгөөд уг мэдээллийн сан нь анхдагч эх сурвалж байна.

Суурь мэдээллийн санд хуульд заасны дагуу Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн сан Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан хамаарна.


3. Төрөлжсөн мэдээллийн сан.

Суурь мэдээллийн сангийн мэдээлэл үндэслэн, эсхүл мэдээлэл хариуцагчаас хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрөлжсөн мэдээллийн санг үүсгэх бөгөөд Засгийн газраас баталсан “Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”-ын дагуу үүсгэж Цахим Хөгжил, инновац, харилцаа холбооны яам бүртгэн баталгаажуулснаар Үндэсний дата төвд байршина.

4. Төрийн мэдээлэл солилцооны систем ашиглах

Засгийн газраас баталсан “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасны дагуу үндсэн систем нь “Үндэсний дата төв” УТҮГ-т байрших төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” систем байна.

“И-Монгол академи” УТҮГ нь үндсэн системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. Цахим Хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүсэлт гарган гэрээг байгуулна. Мэдээлэл хариуцагч нь өөрийн хариуцсан мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, аюулгүй байдлыг хариуцна.



Долоо. Ёс зүйн бүрэлдэхүүн хэсгүүд

Шинэ технологи, шинэ боломжууд бий болохын хэрээр түүнийг илүү хариуцлагатай ашиглах шаардлага гарч байна. Үүнд тэгш боломж, нөөц, аюулгүй хэрэглээ, мэдээллийн аюулгүй байдлыг онцлон авч үзнэ.



“Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” дахь ёс зүйн асуудлуудыг авч үзэхийн тулд дараах асуултуудыг асууж шалгаарай. Үүнд:

- ✓ **Тэгш боломж:** “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” нь хамгийн эмзэг бүлгийн хүн амд хүрч чадах үйлчилгээг дэмжих үү?
- ✓ **Нөөц:** “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” нь нөөцийн зохицуулалтыг үр дүнтэй, үр өгөөжтэй хийж чадаж байна уу?
- ✓ **Аюулгүй хэрэглээ:** “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” нь технологи, багаж хэрэгслийн аюулгүй хэрэглээг дэмждэг үү? Эдгээрийг нотлох баримтад тулгуурлан хийж, шалгаж байгаа юу? Дэвшилтэд технологийг хэрхэн аюулгүй ашиглах вэ?
- ✓ **Нууцлал ба мэдээллийн хамгаалалт:** “Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” нь нууц мэдээлэл, өгөгдлийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж байна уу?

Зургаа. Хүрэх үр дүн

Төрийн байгууллагуудын зохион байгуулалт сайжирч, үйл ажиллагааны зардал буурч, иргэн, аж ахуй нэгжид хүргэж буй үйлчилгээ ил тод, түргэн шуурхай байдал сайжирч, улмаар хүнд сурталгүй болно. Үүнд:

1. Орон нутаг нь цахим технологийг нийгэм, эдийн засаг, засаглал, байгаль орчны чиглэлээр өргөн хүрээнд нэвтрүүлнэ.
2. Иргэдийн амьдрах болон ажиллах орчныг өөрчлөхийн тулд мэдээлэл, харилцаа холбооны технологийг өргөн хүрээнд нэвтрүүлсэн, олон төрлийн үйлчилгээг санал болгодог болно.
3. Төрийн байгууллага, төрийн үйлчилгээнд цахимжилт өргөн нэвтэрнэ.
4. Орон нутгийн салбаруудын эко систем бий болж, цахим засаглалыг дэмжсэн, их өгөгдлүүдийг бүрдүүлсэн системүүд хөгжинө.
5. Орон нутгийн салбар бүрийн иргэнээс төрд, төрөөс иргэн, хувийн хэвшилд чиглэсэн бүхий л төрийн их дата өгөгдөлд суурилсан мэдээллийг боловсруулан, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, төрийн захиргааны байгууллагууд болон иргэд хоорондын итгэлцэл, ил тод байдал бий болно.
6. Орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, бодитой, хэмжигдэхүйц тоон мэдээллээр бодит цагийн горимд хангах техникийн боломж бүрдэнэ.
7. Орон нутгийн орон зайн мэдээллийн систем бий болж, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангадаг болно.



8. Иргэн, аж ахуй нэгжүүдийн бизнес эрхлэхтэй холбоотой төрөөс үзүүлж буй үйлчилгээний бүхий л мэдээллийг нэг цэгт төвлөрүүлэн харуулах боломж бүрдэнэ.
9. Орон нутгийн асуудлыг шийдэхдээ инновац, шинэ мэдлэгийг олон талаар ашиглана.
10. Орон нутгийнхаа иргэдийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг болно.
11. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэх төрийн үйлчилгээний тоо, чанар хүртээмж нэмэгдэнэ.
12. Төрийн байгууллагуудын интернэтийн хурд сайжирч, цахим хурал зөвлөгөөн, сургалт, хэлэлцүүлэг зэрэг аливаа арга хэмжээг өргөтгөсөн хэлбэрээр шуурхай зохион байгуулах боломж бүрдэнэ.
13. Иргэдийн цахим ур чадвар нэмэгдсэн байна.
14. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, төрийн албан хаагчдын цахим албан хэрэг хөтлөлт, дотоод удирдлагын системийн ашиглалт сайжирна.
15. Цахим орчинд аюулгүй байдлаа хангах мэдлэг, мэдээлэл сайжирч, нийгмийн үйлчилгээг иргэд цахимаар авч хэвшинэ.
16. Хүрээлэн буй орчны төлөвлөлт цахим хяналтад орж, удирдлагаар хангахад хялбар болсон байна.
17. Салангид бус нэгдсэн системтэй цахим аймаг, хот болж хөгжинэ.
18. Аймаг, хотыг ухаалгаар удирдах их өгөгдөл (Big data) бий болно.
19. Авлигагүй, бизнест ээлтэй аймаг, хот болно.
20. Нутгийн удирдлагын хүрээнд сайн засаглалыг бүрдүүлнэ.
21. Технологийн дэвшлийг үр дүнтэйгээр нэвтрүүлнэ.
22. Байгалд ээлтэй, эрүүл мэндэд хоргүй ногоон аймаг, хот болно.

Долоо. Хяналт-шинжилгээ үнэлгээ, тайлагналт

Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил тухайн оны 12 дугаар сард багтаан Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлнэ.

“Цахим-Аймаг, Ухаалаг-Хот” зөвлөмжийн хэрэгжилтэд Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх бөгөөд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил тутамд тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь 2 жилд нэг удаа аймгуудын цахим шилжилтийн нөхцөл байдлыг судалж, индекс гарган нийтэд зарлана.



Хавсралт.

ТӨРИЙН БОЛОН МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧИЙН СИСТЕМҮҮДИЙН ЖАГСААЛТ

№	Мэдээллийн систем	
1.	Нээлттэй мэдээллийн систем	shilen.gov.mn
2.	Зөвшөөрлийн нэгдсэн систем	license.mn
3.	Төрийн судалгааны нэгдсэн сан	sudalgaa.gov.mn
4.	Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн сан	
5.	Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан	ezurchil.gov.mn
6.	Эрх зүйн мэдээллийн сан	legalinfo.mn
7.	Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем	opendata.gov.mn
8.	Татвар төлөгчийн нэгдсэн систем	itax.mta.mn
9.	Нийгмийн даатгалын нэгдсэн систем	ndaatgal.mn
10.	Халамжийн нэгдсэн систем	ehalamj.mn
11.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим систем	health.gov.mn
12.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын систем	burtgel.gov.mn
13.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын систем	egazar.gov.mn
14.	Хот байгуулалтын кадастрын цахим систем	urban.gov.mn
15.	Үндэсний архивын цахим сан хөмрөг	e-archives.gov.mn
16.	Гадаад харилцааны төв архивын систем	mfa-archives.mn
17.	Боловсролын мэдээллийн технологийн төвийн систем	esis.edu.mn
18.	Гаалийн цахим үйлчилгээний систем	gaali.mn
19.	Цахим санхүүгийн тайлангийн систем	e-balance.mof.gov.mn
20.	Цагдаагийн ерөнхий газрын торгуулийн систем	torquuli.police.gov.mn
21.	Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн нэгдсэн систем	hrm.csc.gov.mn
22.	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем	itc.gov.mn
23.	Төрийн худалдан авах үйл ажиллагааны систем	tender.gov.mn
24.	Төрийн сангийн систем	GFMIS
25.	Шилэн дансны систем	shilendans.gov.mn
26.	Тээврийн хэрэгслийн бүртгэл	VRS
27.	Техник хяналтын үзлэгийн бүртгэлийн систем	
28.	Өрхийн мэдээллийн нэгдсэн сан	
29.	Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны систем	
30.	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн сан	Licemed.mohs.mn
31.	Төлбөр тооцооны систем	Ebarimt.mn
32.	Төрийн мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем	system.gov.mn
33.	Төрийн үйлчилгээний бүртгэл	services.khurdan.gov.mn
34.	... гэх мэт	